

“НОГООН МАНДАЛГОВЬ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

1.Мандалговь хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, олон нийтийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл эко орчныг бүрдүүлэх.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

2.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ургамлан болон орчин үеийн шийдэл бүхий ургамлан хашлага бий болгож тэдгээрийн арчилалт хамгаалахад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуй нэгжийг сурталчилгааны бодлого, нийгмийн хариуцлагатай нь уялдуулж татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

2.2. Мандалговь хотын нутаг дэвсгэр дэх орон сууцны хороолол дундах бичил ногоон байгууламжийн арчилгааг тухайн орчны оршин суугчид, мэргэжлийн байгууллагын оролцоотой сургалтанд хамруулж, үнэлгээ тогтмол хийж хэвшүүлнэ.

2.3. Төрийн зарим чиг үүргийн дагуу байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүд өөрсдийн санал, оролцоонд ажиллана.

2.4. Хотын төвд зам дагуу ургамлан хашлага бий болгох ажилд иргэд, аж ахуй нэгжийг татан оролцуулах замаар мод тарина.

2.5. Мандалговь хотод цэцгийн баярыг зохион байгуулна.

Гурав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан Ажлын хэсэг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах үүрэг хүлээнэ.

3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зохицуулалтыг хийх, тайлан мэдээ, мэдээллийг боловсруулж дүгнэх, сургалт судалгааны ажлыг зохион байгуулах, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан	Санхүүжилт
1	Мод үржүүлгийн газар байгуулах	-жилд 20,000 суулгац гаргах боломтой мод үржүүлгийн нөөц талбай бий болгоно.		
2	Мод бут, сөөгны үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	-5 сард мод бут, ногоон байгууламжийн чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхлэдэг байгууллагуудыг урьж авчиран Мандал худалдааны төвийн гадаах талбайд үзэсгэлэн гарсан байна.		
3	05-р сарын 31-нд Мандалговь хотын төв Г.Чагдаржавын талбайд цэцгийн баяр зохион байгуулна.	-сургууль тус бүр 1000, цэцэрлэг тус бүр 500, Хот тохижуулах газар 6,000 цэцгийн үрсэлгээ бэлтгэж ургуулсан байна. -үрсэлгээний бортого 15,000ш авах. -6х20 хэмжээтэй хүлэмж авах.	Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нар, хот тохижуулах газар	-1,5 сая -3,7 сая
4	Ногоон байгууламжийн усалгааны зориулалт бүхий гүний худаг гаргах.	Аюулгүйн тойрогт хотын төвийн ногоон байгууламжийн усалгаа арчилгаанд ашиглагдах гүний худаг гаргасан байна.	Засаг дарга ХТГ дарга	

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан	Санхүүжилт
5	Хотын төвийн н о г о о н байгууламжийн арчилгаа, хэлбэржүүлэлт х и й н э .	-Модны тайралт, хэлбэржүүлэлтыг цаг тухай бүрт нь хийж байх. -Багаж хэрэгсэл авах.		-1 сая
6	М а н д а л г о в ь х о т ы г ногооруулах б о д л о г ы н баримт бичиг боловсруулна.	- М а н д а л г о в ь хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 3 жилийн хугацааны бодлогын баримт бичиг боловсруулна. -Мандалговь хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус сургууль, цэцэрлэгийг гадна талбайн батлагдсан “ Д е н д р о п л а н ” зургийн даалгавартай болсон байна.		-2 сая
7	Сургалт зохион байгуулна.	-иргэн -төрийн байгууллага -аж ахуй нэгжүүдийн дунд зохион байгуулсан байна.	Н о г о о н байгууламж хариуцсан мэргэжилтэн	-3 сая

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан	Санхүүжилт
8	“Ногоон Мандал 2020” болзолт уралдаан зохион байгуулна.	-том ААН-үүд /Төрийн байгууллагууд, ОНӨҮГазар, ХХК, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг Супермаркет, Зочид буудал, ресторан, бүх төрлийн үйлдвэр, банк, зах, худалдааны төвүүд/-жигиг ААН-үүд / Үсчин, гоо сайхан, зурагчны газар, эмийн сан, хувийн эмнэлэг, авто засвар, авто угаалга, гуанз, кафе, баар, клубууд, хүнсний дэлгүүр, нийтийн халуун ус, ШТСтанц... гм -баг бүрээс нэг өрх		3 сая
9	Төв сандан нөхөн тарилтыг хийнэ.	-Буян нэмэхийн өргөн чөлөөний “Дендроплан” зургийн даалгавар боловсруулж зургийн дагуу нөхөн тарилт хийсэн байх.		
10	Гэрэлт гудамж байгуулна	-Буян нэмэхийн өргөн чөлөөг гэрэлт гудамж болгох.		-10 сая

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан	Санхүүжилт
11	автозам дагуу ногоон байгууламж тарьж ургуулна.	-Улаанбаатар хотоос Хотын төврүү орж ирэх зам дагуу мод тарьсан байна.		-10 сая
12	Мандалговь хотын 55 жилийн ойд зориулан байгууламж бий болгоно.			9 сая

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг тор дурьдсан эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Төвлөрсөн болон орон нутгийн төсөв
- Байгаль хамгаалах сан
- Олон улсын байгууллага, хандивлагчдаас өгч буй тусламж, дэмжлэг, хандив.
- Төр, олон нийт, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж.
- Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн.

6.1. Мандалговь хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчны нэгдсэн төлөвлөлттэй, нийтийн эзэмшлийн зүлэгт талбайг 5000м2 –аас доошгүйгээр бий болгоно.

6.2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэгийн ногоон байгууламж тарьж ургуулах, түүний арчилгаа, хамгаалалтанд иргэд, аж ахуй нэгжийн оролцоо нэмэгдсэнээр навчит болон шилмүүст 5000-аас доошгүй мод, 30,000 –аас доошгүй ургамлан хашлага бүхий ногоон байгууламж бий болгож ургалтын чанарыг 75 хувиас дээш ургуулах.

6.3. Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэд, бүлгийн санал санаачлага, оролцоонд тулгуурлан холбогдох төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажилласнаар навчит болон шилмүүст 5000-аас доошгүй мод, САХүрээлэн, Арвижих төгөлд таригдана. Мод, бутны арчилгаа, хамгаалалт, нөхөн тарилтыг горимын дагуу зохион байгуулж, ургалтын чанарыг 80 хувиас дээш ургуулна.

Долоо. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрээр гаргаж, биелэлтийн тайланг ажлын хэсгээр хэлэлцэж улирал бүр хэрэгжилтийг тооцно.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр засгийн газрын 89-р тогтоолын хавсралт маягтаар гаргаж Сайнцагаан сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнана.

***САЙНЦАГААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР***